



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/69

Хужирт сум

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8.1, 9.8.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны "Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" А/240 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.
2. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шүлхий өвчний яаралтай дархлаажуулалтад ажиллах хүн хүч, шатахуун, бусад холбогдох зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дархлаажуулалтын ажлыг товлосон хугацаанд үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг ажлыг хэсэг (Б.Дэмбэрэл), малчин, мал бүхий иргэдэд мэдээлж, малыг бүрэн хамруулахад анхаарч ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Дархлаажуулалтад шаардагдах зардлыг малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй

622301137
D:Alban bichig;Zahiramj 2023